СЭНДЛИ ББСБ НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр №1 Улаанбаатар хот

Хурлын төрөл: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
Хурлын огноо: 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр
Хуралдсан газар: Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Арт хаус центр, 6-н давхарын танхимд болон цахимаар
Хурал эхэлсэн цаг: 14:00

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг танилцуулна. Үүнд:
1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлан;
2. Ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэр;

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэж, шийдвэрлүүлнэ. Үүнд:
1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсөв батлах;

Хурлын дарга Б.Наранбат: Сайн байцгаана уу? “Сэндли ББСБ” Нээлттэй хувьцаат компанийн нийт хувьцаа эзэмшигчдэд энэ өдрийн мэнд хүргэе. Компанийн ХЭ-ийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах шийдвэрийг холбогдох хууль, журмыг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдөр хуралдаж, 04 тоот тогтоолоор шийдвэрлэсэн. Хувьцаа эзэмшигчдийн хурал бол компанийн эрх барих хамгийн дээд байгууллага байдаг.Энэ удаагийн хурлыг танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж байна. Ингээд Монгол орны өнцөг булан бүрээс цахимаар оролцож байгаа болон энд хүрэлцэн ирсэн та бүхэнд талархлаа илэрхийлэн, Сэндли ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал нээснийг мэдэгдье. Ингээд та бүхэнд хурлын дэгийг танилцуулъя. */Хурлын дарга Б.Наранбат хурлыг эхлүүлж, хурлын дэгийг танилцуулав./* Ингээд Хувьцаа эзэмшигчдийн ирцийн мэдээлэл гарсан байна. Тооллогын комиссын гишүүн П.Болорчулуун танилцуулна.

П.Болорчулуун: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Ингээд Сэндли ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн мэдээллийг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулъя. */Хурлын ирцийг танилцуулж, хурал хүчин төгөлдөр болсныг зарлав./*

Хурлын дарга Б.Наранбат: Хурлын ирцийг танилцуулсан Тооллогын комиссын гишүүн П.Болорчулуун танд баярлалаа. Холбогдох хуулийн дагуу хурлын ирц хүчин төгөлдөр болсон байх тул бид хурлаа хөтөлбөрийн дагуу үргэлжлүүлэн хурлын үндсэн хэсэгт шилжье. Сэндли ББСБ ХК-ийн 2026 оны ээлжит хурлаар танилцуулах асуудал болох Сэндли ББСБ ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлан болон аудитлагдсан санхүүгийн тайлан, Ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэрийг танилцуулья. */Хурлын дарга Б.Наранбат компанийн 2025 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайлан болон ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэрийг танилцуулав./*

Хувьцаа эзэмшигчид асуулт асуув.

Хувьцаа эзэмшигч: Сайн байна уу? Надад хэд хэдэн асуух зүйл байна. Сэндли нээлттэй болон хаалттай бонд ямар ҮЦК-уудаар дамжуулан татаж байгаа вэ? Итгэлцлийн хүү хэдэн хувьтай байгаа вэ? Мөн хувьцаагаар ногдол ашиг тараах шинэ боломж нээгдэж байгаа гэж байна, хэрвээ хувьцаагаар ногдол ашиг тараах болбол 1 ширхэг хувьцаатай хүн дээр яаж олгогдоно гэсэн үг вэ? Бутархай хувьцаа олгогдоно гэсэн үг үү? Энэ 2025 оны турш Сэндли нийт хэдэн төгрөгийн эх үүсвэр татсан бэ?

Б.Наранбат: Заа баярлалаа. Эх үүсвэртэй холбоотой асуултанд Хөрөнгө оруулалт хариуцсан захирал Н.Билгүүн хариулах болно. Миний хувьд хувьцаагаар ногдол ашиг тараахтай холбоотой асуултанд хариулья. Бутархай хувьцаа гэж байхгүй. Үүнийг хэрэгжүүлэхээр болбол бид тусдаа хэрхэн хэрэгжүүлэх талаар журам, заавар гаргана. Гэхдээ урьдчилсан байдлаар бутархай хувьцаагаар олгох бололцоо байхгүй, хамгийн багадаа 1 ширхэг хувьцаагаар ногдол ашиг тараах боломжтой. Жишээ нь 1 ширхэг хувьцаанд 150 төгрөгийн ногдол ашиг тараах байлаа гэж бодоход 20 хувиар тооцвол та 5 ширхэг хувьцаатай эзэмшиж байж 1 ширхэг хувьцааг ногдол ашгаар нэмж авна гэсэн үг. Хамгийн багадаа 20% нь 1 ширхэг хувьцаанд хүрэхгүй буюу 5-аас доош ширхэг хувьцаатай бол тэдгээр хүмүүст ногдол ашиг тараах боломжгүй л гэсэн үг болно. Урьдчилсан байдлаар тиймэрхүү байдлаар шийдэх болов уу л гэж бодож байна. Гэхдээ СЗХ-ны журам юу гэж батлагдан ямар байдлаар хэрэгжихээс шалтгаалах байх.

Н.Билгүүн: Итгэлцлийн хүү 19,2% байна. Хэрвээ та манай Сэндли-д хувьцаанаас бусад бүтээгдэхүүнээр хөрөнгө оруулахыг хүсвэл манай хамтран ажиллагч байгууллагууд болох Өлзий энд Ко капитал ҮЦК, Райнос инвесмент ҮЦК ХХК, Стоклаб секьюритиз ҮЦК, Тэнгэр капитал ҮЦК, Мазаалай ҮЦК нараас дамжуулан авч болно. Бондын хувьд андеррайтер нь Өлзий энд Ко капитал ҮЦК болон Райнос инвестмент ҮЦК байгаа. Энэ жилийн 8-н сард нээлттэй бонд гаргахаар төлөвлөж байна. Хүүний түвшинг одоогоор тогтоогүй байна.

Хурлын дарга Б.Наранбат: Нээлттэй бондын хувьд хамгийн багадаа 16,8%, хамгийн ихдээ 17,2% байна байх гэж таамаглаж байна. Нээлттэй учраас татвар нь 10% биш, 5% хувь шүү дээ. Бид аль болох л хамгийн багаар гаргахыг хичээнэ. Гэтэл Монголбанк мөнгөний хатуу бодлого бариад, бодлогын хүү өндөр болчихсон байгаа. Банкнуудын хадгаламжийн хүү буурахгүй, тийм байгаа учраас хямдхан эх үүсвэр татах нь гол биш, эх үүсвэрээ аваад үйл ажиллагаагаа явуулж байх нь чухал болж байна. Гаргах хэмжээ нь энэ жил өсөөд 18-20 тэрбум гаргах байх гэсэн төсөөлөл байна.

Хувьцаа эзэмшигч: Итгэлцэлийн хүү 19,2% гэж байна. Ниосити-ээс орон сууц худалдан авч буй гадаадад байгаа иргэдэд олгож буй мортгежийн зээл чинь адилхан 18%,19% м байна. Тэгэхээр 19%-иар эх үүсвэр татчихаад 19%-ийн зээл олгох чинь ашигтай юу?

Хурлын дарга Б.Наранбат: Таний хэлдэг үнэн. Гэхдээ лизингийн хөтөлбөр шиг бид Сэндли-рүү татаас өгөх ёстой асуудал байгаа. Тэр нь 4% байгаа. Нөгөө талдаа бидний нийт эх үүсвэр 19,2% гэж бодож болохгүй. Эх үүсвэрийн дундаж хүү түүнээс доошоо байгаа.

Хувьцаа эзэмшигч: Хувьцаагаар ногдол ашиг тараахаас өөрийн хөрөнгө өсөх давуу талтай байдаг. Сэндли эмплойе гээд компани хэрхэн ногдол ашиг авах вэ? Танай ажилчид хувьцаа нэмж авна гэсэн үг үү?

Хурлын дарга Б.Наранбат: Сэндли эмплойе ХХК-ийн хувьд ХХК-ийн журмаар Сэндли-ийн 20,000,000 ширхэг хувьцааг эзэмшиж байгаа. Энэ компанийн хувьцааг одоогоор 30%-ийг нь ажилчид, 70%-ийг нь толгой компани нь эзэмшиж байгаа. Яваандаа бид ажилчиддаа хувьцаагаа толгой компаниасаа шилжүүлж 100%-ийн ажилчдын хувьцаа эзэмшдэг компани болгохоор төлөвлөж ажиллаж байгаа. Нэг ёсондоо Сэндли-ийн нээлттэй арилжаанд шууд оролцохгүйгээр Сэндли эмплойе-оор дамжуулан хувьцаа эзэмшиж байгаа гэсэн үг юм.

Хувьцаа эзэмшигч: Та бүхний танилцуулсан хувьцаагаар ногдол ашиг тараах боломжийн хувьд их таатай, баярлаж хүлээж авч байна. Энэ жилийн хувьд ногдол ашиг тараахгүй хэмээн шийдвэрлэсэнийг ойлгож байна. Хэрвээ одоо боломж байвал, энэхүү хувьцаа

эзэмшигчдийн хуралд ихэнх нь ирээд ирц хангалттай байгаа юм чинь хувьцаагаар ногдол ашиг тараах тухай шийдвэр гаргаад, албажуулж болох уу?

Хууль, эрхзүй хариуцсан захирал Л.Нарантуяа: Таний санааг ойлгож байна. Гэхдээ 1-рт энэхүү хувьцаагаар ногдол ашиг тараах асуудлын тухайд компанийн тухай хуулиараа боломжтой боловч, түүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаарх СЗХ-ны журам хараахан албан ёсоор батлагдаж, мөрдөгдөж эхлээгүй байна. Мөн түүнчлэн ногдол ашиг тараах эсэх шийдвэрийг компанийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж байж гардаг. Иймд одоогийн нөхцөл байдлын хувьд бид таний саналыг тэмдэглэлд тусган, ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудалд оруулан, хэлэлцүүлэх боломжтой байна. Өөрөөр хэлбэл энэхүү хурлын тэмдэглэлд таний санал тусгагдаж, уг саналыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцсэнээр эцсийн шийдвэр гарах бололцоотой.

Хурлын дарга Б.Наранбат: Та бүхэнд өөр асууж, тодруулах зүйл байхгүй бол та бүхэн саналаа өгөнгөө цай, кофе уугаарай. Ингээд түр завсарлая. */Завсарлага 15 минут үргэлжлэв/*

Хурлын дарга Б.Наранбат: Санал хураалтын шугам хаагдсан байна. Үүгээр санал хураалт явагдаж дууссан тул санал хураалтын дүнг уншиж танилцуулна уу хэмээн Тооллогын комиссын гишүүн П.Болорчулууныг урьж байна.

П.Болорчулуун: Хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүн гарлаа. Та бүхэнд танилцуулъя.

Хурлын дарга Б.Наранбат: Санал хураалтын дүнг танилцуулсан Тооллогын комиссын дарга А.Итгэлтэд баярлалаа. Ийнхүү Сэндли ББСБ ХК-ийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал өндөрлөж байна. Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа идэвх санаачлагатай оролцож, өөрсдийн үнэт саналаа өгсөн та бүхэндээ баярлалаа. Компанийн цаашдын үйл ажиллагаанд та бүгдийн оролцоо юу юунаас илүү чухал гэдгийг энэ дашрамд хэлмээр байна. Ингээд “Сэндли ББСБ” ХК-ийн өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал өндөрлөснийг мэдэгдье.

ШИЙДВЭРЛЭСЭН АСУУДАЛ:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайланд гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг батлав.

Зөвшөөрсөн		**Татгалзсан**		**Түдгэлзсэн**	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
157,895,312	99,58741%	100	0,00006%	655,166	0,41322%

2. Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2024 оны төсөв батлав.

Зөвшөөрсөн		**Татгалзсан**		**Түдгэлзсэн**	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
157,895,312	99,58741%	100	0,00006%	655,166	0,41322%

Хурлын дарга Б.НАРАНБАТ /.....

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Мөнхцэцэг /.....